



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 8/443

Мөрөн сүм

Г Захиалагчийн зарим эрх, үүргийг  
шилжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх хэсэгт заасан үнэлгээний хороо байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.2 дэх хэсэгт заасан үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах, мөн хуулийн 46.1.3 дахь хэсэгт заасан үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг шалгарсан оролцогчид, төндерээс татгалзсан тухай мэдэгдлийг шалгараагүй оролцогчид хүргүүлэх, мөн хуулийн 46.1.4 дэх хэсэгт заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах эрхийг тус тус аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсүгэй.

3. Бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт (ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөл) бэлтгүүлэх, хянах, баталгаажуулах чиг үүргийг аймгийн Засаг даргын орлогчид хариуцуулсугай.

4. Шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатар, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөн-Эрдэнэ, Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсорогдог нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйнхэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj

6711011771